

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ  
ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2025.12.10

Улаанбаатар

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүн	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>						
<b>2.3. Эрүүл монгол хүн</b>						
<b>2.3.1. Нийгмийн эрүүл мэнд</b>						
2.3.1.1	Эрүүл амьдралын хэв маяг, <b>урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн</b> нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	<b>Нэг.</b> Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг байгуулах	2024-2028	Австри улсын ЗГ, Монгол улсын ЗГ  10 сая евро	Тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Монгол улсад хавдрын эрт илрүүлгийн сүлжээг бий болгосноор эрт үедээ илэрсэн хавдрыг хямд зардлаар төгс эмчилж, хянах боломж бүрдэнэ. Ингэснээр хүн амын хавдраас шалтгаалсан хөдөлмөрийн чадвар алдалт болон нас баралт буурна. МУ-ын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын зээлийн хөрөнгөөр Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан журмын 13 дугаар хавсралтын жагсаалтад <b>“Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах төсөл”</b> (2021-2024 он)-ийг хэрэгжүүлэхээр болсон. Уг төслийн хүрээнд: 1. ЭМС-ын 2022.09.27 өдрийн А/477 тоот тушаалаар хийгдэх ажлын жагсаалтыг шинэчлэн батлуулсан. 2. Тендерийн үйл ажиллагаа: Үндэсний хэмжээний эрт илрүүлгийн сүлжээг бий болгох, бэхжүүлэх програм хангамжийг хөгжүүлэх, тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалтын чиглэлээр тендерийн бичиг баримтыг боловсруулан, ЭМЯ-нд 2022 онд хүргүүлсэн. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 3 удаа зарлагдаж 2023 оны 10 сарын 30 өдөр зарласан ЭМЯ/2023/10/30 дугаартай төсөлд Австри улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай Vamed ingeneering GmbH компани шалгарч

					<p>гэрээг 2024.01.10-ны өдөр “Гэрээ байгуулах эрх олгох тухай” албан тоотоор мэдэгдэж, 2024.05.08-ны өдөр Зээлийн гэрээ байгуулагдагдан, 2024.12.10 өдрөөс хэрэгжиж эхэлсэн.</p> <p>2025 оны 12 сарын байдлаар уг төслийн гэрээний дагуу:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Програм хангамж: -ийн хөгжүүлэлт 80 хувьтай байгаа бөгөөд ЭМЯ-ны зүгээс Health ESB бичил сервисийн API нэвтрэх эрх, Анхан шатны маягтуудыг батлах тушаал хүлээгдэлтэй байна.</li><li>2. Сургалт, сурталчилгааны тоног төхөөрөмж: (сервери-2, Суурин компьютер-4, принтер-2, ухаалга дэлгэц-2) нийлүүлэгдсэн.</li><li>3. Тоног төхөөрөмж: Иж бүрэн уян дуран (Тус бүр 10 дурантай), Дурангийн хэт авиа-1, Коагуляцийн аппарат-2, Өндөр хүчин чадалтай эхоны аппарат-2 хүлээн авч ашиглаж байна.</li><li>4. Өндөр өртөгтэй аппаратууд: MRI, СТ, Angiography, Mammogram-ыг ХСҮТ-д суурилуулахад ерөөнүүдийг бэлтгэх засврын ажлыг хийсэн ба аппаратуудыг бүрэн суурилагдаж дууссаны дараа хүлээлцэхээр байна.</li></ol> <p>3. Зонхилон тохиолдох <u>7 байрлалын хорт хавдрын эрт илрүүлгийн зааврыг</u> боловсруулж, батлуулахаар ЭМЯ-нд илгээсэн.</p> <p>Энэхүү зааврын дагуу зорилтот бүлгийн хүн амын дунд элэг, ходоод, улаан хоолой, уушги, умайн хүзүү, хөх, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг оношилгооны арга зүйн сургалтыг зохион байгуулж, Улаанбатаар хотын 9 дүүргийн ЭМБ, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн нийт 400 гаруй эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан.</p>
--	--	--	--	--	--

		<p><b>Хоёр.</b> Товлолт насны хүн амыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулах товллол, давтамж болон төлбөрийн хэмжээг шинэчлэх</p>			<p><b>ЭМДҮЗ-ийн 2025 оны 10 дугаар тогтоолоор</b> Эрт илрүүлэгт хамруулахдаа товллолт насны, даатгалтай иргэдийг түргэвчилсэн сорилоос эхлэн, нарийвчилсан шинжилгээгээр баталгаажуулах байдлаар ЭМБ-ын шатлал бүрт санхүүжилтийн зохицуулалтыг хийж, харъяалал харгалзахгүйгээр, төлбөргүй байхаар тусгасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Элэг (В, С вирус илрүүлэх түргэвчилсэн сорил, Elisa- баталгаажуулах шинжилгээ, ачаалал тоолох)</li> <li>- Улаан хоолой-ходоод (дурангийн оношилгоо, ажилбар, биопси)</li> <li>- Бүдүүн-шулуун гэдэс (өтгөнд далд цус илрүүлэх, дурангийн оношилгоо, ажилбар, биопси)</li> <li>- Умайн хүзүү (эсийн шинжилгээ ХПВ, ПАП, PCR, кольпоскопи)</li> <li>- Хөх (хэт авиа, маммографи, биопси)</li> <li>- Уушги (Бага тунт болон тодосгогчтой КТ, биопси)</li> </ul> <p><b>Улсын хэмжээнд 2025 оны эхний 10 сарын байдлаар:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын хэмжээнд 2025 оны эхний 10 сарын байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан эрт илрүүлэгт зорилтот насны нийт 69356 (28.1%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 4.4 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй. Үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн 9 тохиолдол бүртгэгдсэн байна.</li> <li>2. Хөхний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 484279 эмэгтэй хамрагдсанаас 854 (0.2%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр</li> </ol>
--	--	--	--	--	--

					<p>ээрэг буюу хорт хавдрын шинэ өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн байна.</p> <p>3. Хорт хавдрын эрт илрүүлгийн бүртгэлд хэрэглэх анхан шатны маягт, хорт хавдрын бүртгэлийн АМ-5, хяналтын хуудсыг дахин шинэчилэн боловсруулж, ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 01/1450 албан тоотоор ЭМХТ-д хүргүүлсэн.</p> <p>4. Олон улсын хорт хавдрын бүртгэлийн холбоо (IACR)-нд 2024 оны умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн тоо мэдээ илгээсэн.</p> <p>5. ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албатай хамтран Монгол улсад 10 сарыг дархлаажуулалтыг дэмжих сарын аяны хүрээнд дараах сургалтуудад “Хорт хавдрын өнөөгийн нөхцөл байдал-Умайн хүзүүний хорт хавдар” сэдвээр ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын алба, НЭМҮТ-тэй хамтран оролцлоо.</p> <ul style="list-style-type: none"><li>- Нийслэлийн 6 дүүргийн ЕБС-ын багш, нийгмийн ажилтан, сайн дурын ажилтан нарт</li><li>- Замын-Үүд, Дорноговь, Говь-Сүмбэр аймгийн НЭ-ийн эмч, мэргэжилтэнүүд</li><li>- Нийслэлийн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвд хамтарсан сургалтыг хийлээ.</li></ul>
--	--	--	--	--	---

2.3.1.3	<p>“Эрүүл шүд”, <b>“Хорт хавдраас сэргийлэх, хянах”</b>, зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх “Эрүүл Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.</p>	<p>“Хорт хавдраас сэргийлэх, хянах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ</p>	2024-2028	Улсын төсөв	<p>“Хорт хавдраас сэргийлэх, хянах” хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь</p>	<ol style="list-style-type: none"> <li>2024 онд ЭМС-ын тушаалаар томилогдсон ажлын хэсэг <b>“Хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр, 2025-2028”</b>-ийг ДЭМБ-ийн техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 сарын 12-ны өдрийн А/241 дүгээр тушаалаар батлагдсан.</li> <li>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой үндэсний түвшинд хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд ОУАЭА-ийн <b>"imPACT Review in-country expert mission team"</b> 2024 онд хөндлөнгийн үнэлгээ хийсэн. Үнэлгээгээр хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон улсын жишигт нийцсэн цогц агуулга, багтаамж бүхий сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж зөвлөсний дагуу төгсөлтийн дараах төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх <b>11 төрлийн сургалтын хөтөлбөрийг</b> шинэчилэн боловсруулж, ЭМЯ-ны Эмнэлгийн мэргэжилтний салбар зөвлөлөөр 2025 онд батлуулсан.</li> <li>ЭМЯ-наас 2025.09.25-нд зохион байгуулсан “Тамхины хяналтын бодлогын хэлэлцүүлэг”-т холбогдох мэргэжилтнүүд оролцож, “Тамхины хяналтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгад саналаа оруулсан.</li> <li>Хүн амын дундах хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд: <u>НЭМҮТ-тэй хамтарсан нөлөөллийн аян-4, Рийл бичлэг-4 (хандалт-417К, хуваалцсан-1,8К)</u> - “Элэг эрүүл бол амьдрал эрүүл” аян</li> </ol>
---------	---	---	-----------	-------------	---	---

						<ul style="list-style-type: none"> <li>- “Хавдар халдварт өвчин шиг гэнэт өвчлүүлдэггүй” нийтлэл,</li> <li>- “Ходоод руугаа өнгийе!” аян</li> <li>- “Бүтэн хайрлая бүдүүн гэдсээ” аян</li> </ul> <p><u>Цахим контент:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Видео шторк-3</li> <li>- Баримтат кино-3</li> <li>- Цахим постер (хандалт-14К),</li> </ul> <p><u>Танхимын сургалтаар:</u> 2404 иргэн, хавдартай иргэдийн асран хамгаалагч-4075 иргэнийг хамруулсан.</p> <p><u>Хэвлүүлсэн материал -4800ш</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Умайн хүзүүний хорт хавдаргүй ирээдүй ба Хүний хөхөнцөр вирусийн (ХПВ) эсрэг дархлаажуулалт” товхимол-1000ш</li> <li>- Сэтгүүлчдийн уралдаанд ирүүлсэн бүтээлийн эмхэтгэл-500ш</li> <li>- Хорт хавдрын эрт илрүүлгийн өврийн дэвтэр-300ш</li> <li>- “Зонхилон тохиолдох хавдрын эрт илрүүлэг” 6 төрлийн брошур тус бүр-500</li> </ul>
--	--	--	--	--	--	---

**2.3.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж**

2.3.2.1.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, <b>Хавдар судлалын үндэсний төв-II,</b> Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний	“Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв”	2024-2029	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	-“Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв”-ийг байгуулах ажлын хэсгийн төлөвлөгөөний хэрэгжилт 80-аас доошгүй хувьтай байна. -“Хорт хавдрын эрт	<b>“Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв” төсөл</b> 1. МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор ажлын хэсгийг байгуулан, төслийн ажлыг эхлүүлсэн. 2. Төслийн хүрээнд СХД-ийн 34-р хороо, Баянголын аманд 2024 оны 12 сард 150'000м <sup>2</sup> талбай бүхий газрын зөвшөөрлийг авсан. 3. Ажлын зураг, төсөв боловсруулах шатандаа явж байгаа ба 2025.06.31-нд хүлээн авахаар төлөвлөсөн. 4. Цэвэр, бохир усан хангамж, холбоо, дулаан, цахилгааны шугам сүлжээ зэргийн техникийн нөхцөлүүдийг холбогдох
----------	---	---	-----------	------------------------------------	---	---

	төв/				илрүүлэг, дурангийн оношилгоо, эмчилгээний төвийг өргөтгөн зохион байгуулсан байна.	байгууллагуудаас гаргуулсан. 5. Нийслэл болон СХД-ийн ЗДТГ-тай хамтран төвийн гаднах 3 га талбайд хийгдэх цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа, зураг төслийн ажил явагдаж байна. 6. Куантум солюшн ХХК-тай 2025.05.01-ний өдөр гэрээ байгуулж, урьдчилсан ТЭЗҮ боовсруулах ажил хийгдсэн. 7. Барилгын гаднах хашаажуулалтыг СХД-ийн Дэд бүтцийн хөгжлийн алба, Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлдвэрийн газар хийж байна. 8. Гадна тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг СХД-ийн Захиалагчийн ажлын алба гүйцэтгэж байна. Ажлын явц 80%. <b>“Хорт хавдрын эрт илрүүлэг, дурангийн оношилгоо, эмчилгээний төв” төсөл</b> <ul style="list-style-type: none"> <li>ХСҮТ болон Л ХОЁР ХХК-ийн хооронд 2024.06.07-ны өдөр байгуулсан №НОННХСҮТ202401015 тоот гэрээний дагуу барилгын ажлыг 2024 оны 12 сард эхлүүлсэн.</li> <li>2025 оны 11 сарын байдлаар барилгын хана, дээвэр, сантехникийн ажлыг оролцуулан, барилга угсралтын ажил 83 хувьтай явагдаж байна.</li> </ul>
2.3.2.4	Маш цөөн хийгддэг, өндөр зардалтай тусламж, үйлчилгээг гадаад улсын эмнэлэгтэй хамтын гэрээ байгуулж, тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.	Толгой хүзүүний нөхөн сэргээх мэс засалд 3 хэмжээст төлөвлөлт бүхий дижитал технологийг нэвтрүүлнэ.	2024-2028	Хамтын ажиллагааны гэрээ	-АНУ-ын Langone Health Эмнэлэгт толгой хүзүүний нөхөн сэргээх мэс заслын багийг сургаж	1. Хүний нөөцийг бэлтгэх: АНУ-ын Langone Health эмнэлэгт 2 эмч, 2 сувилагч 2025 оны 2-3 сард сургалтанд хамрагдаж, толгой хүзүүний байрлалын хавдрын өргөтгөсөн мэс заслын дараах 3 хэмжээст төлөвлөлт бүхий нөхөн сэргээх мэс заслын арга технологиос суралцлаа. Дадлагыг хиймэл ясны загвар дээр хавдрын өргөтгөсөн мэс заслын дараах согогийг үүсгэн, түүнд ясны метал бэхэлгээг суурилуулах байдлаар хийж, ажлын байран

					<p>чадавхижуулсан байна.</p> <p>-3 хэмжээст принтер, программ хангамж, цутгаж хэвлэх материалаар хангагдсан байна.</p> <p>Шинэ технологиор 5-аас цөөнгүй мэс заслыг амжилттай хийсэн байна.</p>	<p>дээр уг мэс заслыг биоинженертэй хамтран гүйцэтгэж, дадлагажсан.</p> <p><u>2.Гадаад сургалт:</u> 2025 оны байдлаар ХСҮТ-ийн 98 эмч, мэргэжилтэн 1 сар хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй улс оронд хурал, сургалт, семинарт оролцох, туршлага солилцох байдлаар мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн байна.</p>
2.3.2.6	Иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ.	Орон нутгийн ЭМБ-уудад “Алсын зайн анагаах ухаан-телемедицин” ашиглах боломжийг бүрдүүлнэ	2024-2028	Байгууллагын төсөв	<p>-Батлагдсан журам,</p> <p>-Зохион байгуулсан хурал, үзлэг, зөвлөгөөн, сургалтын тоо</p> <p>-Орон нутгийн санал, хүсэлтээр хийгдсэн үйл ажиллагааны эзлэх хувь</p> <p>-Хамрагдсан ЭМБ, эмнэлгийн мэргэжилтэн</p>	<p>1. Хорт хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Алсын зайн оношилгоо, тусламж үйлчилгээний журам”-ыг 2024 онд батлуулан, хэрэгжүүлж байна.</p> <p>2. Телемедициныг ашиглан, аймаг дүүргийн эмнэлгийн мэргэжилтнийг дараах чиглэлээр чадавхжуулаад байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн эмч нартай хамтарсан зөвлөгөөн,</li> <li>- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний цахим сургалт,</li> <li>- Хими эмчилгээний цахим сургалт,</li> <li>- Хавдар бүртгэгч нарын туршлагаа солилцох цахим уулзалт</li> </ul>
<b>2.3.4.Эрүүл мэндийн салбарын хүний нөөц</b>						
2.3.4.1	Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин,	1.”Хорт хавдрын навигаци болон	2024-2028	Төсвийн болон хувийн зардал	-Туяа эмчилгээнд шинэ	<b>“Хорт хавдрын навигаци болон стереотактик эмчилгээний төв байгуулах” төслийн хүрээнд:</b>

	<p>эмгэгийг оношлох, эмчлэх зорилгоор шинэ, дэвшилтэт технологи, арга, аргачлал нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, гадаадын ур чадвар бүхий мэргэжлийн багийг эх орондоо урьж, туршлага солилцуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>стереотактик эмчилгээний төв байгуулах” төсөл</p>			<p>технологиуд нэвтэрсэн байна. - Элэг, уушги, хөхний хорт хавдарт 4 хэмжээст туяа эмчилгээг хийж эхэлсэн байна.</p>	<p><u>Тоног төхөөрөмжийн хангалт:</u> Төсөл хэрэгжүүлэгч Вamed компани мэдрэлийн мэс заслын 12, туяа эмчилгээний 8 нэр төрлийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, угсралт суурилуулалт хийгдсэн. Ашиглалт 100 хувьтай. <u>Хүний нөөцийг бэлтгэх:</u> 2022 онд Тайвань улсад Мэдрэлийн мэс засал (2), Туяа эмчилгээ (1)-ний 1.5 сарын сургалтанд сургаж, УГТЭ-т дагалдан сургалтанд хамруулсан. Мөн үйлдвэрлэгчийн зүгээс 2023-2024 онд “Aria upgrade”, “True Beam аппаратын операторын” болон “HyperArc” зэрэг ажлын байрны сургалтыг үе шаттай зохион байгуулж, дадлагажуулсан. <u>Чанарын баталгаажуулалт:</u> ОУАЭА-ийн End-to-end хөндлөнгийн аудит 2024 онд хийгдэж, эмчилгээнд ашиглаж эхэлсэн. Нийт 187 хүн (3D CRT-10, VMAT-988 SBRT-5) эмчилгээнд хамрагдсан. <u>Хавдрын туяа эмчилгээнд 8 төрлийн шинэ технологийг нэвтрүүлснээр:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Элэг, уушгины хорт хавдарт- SBRT, Хөхний хавдарт DIBH,</li> <li>- Элэгний хавдарт DEBH технологи бүхий 4 хэмжээст туяа эмчилгээг Монгол улсад хийдэг болсон.</li> <li>- Өдөртөө дунджаар 30-35 хүн зөвхөн гадаад оронд авдаг байсан энэхүү тусламжийг эх орондоо авч байна.</li> </ul>
--	---	--	--	--	--	---

2.3.4.3	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, алслагдсан орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшууллыг нэмэгдүүлнэ.	Хавдар судлалын үндэсний төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2024-2028	Байгууллагын төсөв	Хөтөлбөрийн чиглэл бүрээр үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн байна. Хэрэгжилт 95%-иас доошгүй байна.	ХСҮТ-ийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд дараах 3 чиглэлээр нийт 42 үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох-21;</li> <li>- Эрүүл, аюулгүй ажлын байр бүрдүүлэх-13;</li> <li>- Дэмжлэгт орчныг бий болгох-8;</li> </ul> <b>Хавсралт-1.</b> ХСҮТ-ийн Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны биелэлт
---------	--	---	-----------	--------------------	--	--

ХЯНАСАН: Э.ХИШИГДОРЖ /ХСҮТ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ/

НЭГТГЭСЭН: Ц.БАДАМСҮРЭН /ХСҮТ-ИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, СУРГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА/

Д.АЛТАНЗАЯА /ХСҮТ-ИЙН НЭМСА-НЫ СУРГАЛТ, ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН/

